



СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ

Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер дилер


ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ МЭДЭЭ

2019 оны 8-р сар




МХБ-ийн индексүүд

Топ-20 индекс, 19,427 -4.5% (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)



МХБ-1 индекс, 9,016 -2.1%, МХБ-2 индекс 7,814 -3.8% (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)



Олон улсын индексүүд

Индекс	2019.07.31	2019.08.30	Өөрчлөлт, %
DJIA (US)	26,864	26,118	-2.8%
S&P 500 (US)	2,980	2,927	-1.8%
Nikkei 225 (JP)	21,541	20,690	-4.0%
Hang Seng (HK)	27,584	25,725	-6.7%
DAX 30 (DE)	12,181	11,939	-2.0%
SMI (CH)	9,919	9,896	-0.2%

Валютын ханш

Валют	2019.07.31	2019.08.30	Өөрчлөлт, %
USD	2,666	2,672	+0.2%
EUR	2,973	2,949	-0.8%
JPY	24.56	25	+2.2%
RUB	42	40	-4.4%
CNY	387	374	-3.4%
KRW	2.25	2.21	-1.8%

Арилжааны мэдээ

Хураангуй (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)

Үзүүлэлт	Дүн	Өөрчлөлт, %
Арилжааны хэмжээ, тэрбум ₮	1.8	-88%
Зах зээлийн үнэлгээ, тэрбум ₮	2,493.4	-0.9%
Бүртгэлтэй компани	199	-
Арилжаалагдсан хувьцаа	67	-6.9
Арилжаалагдсан өдөр	22	

Хамгийн их өсөлттэй

Хувьцаа	2019.07.31	2019.08.30	Өөрчлөлт, %
UID	500.00	670.00	+34%
HRD	3,236.00	4,279.00	+32%
MSH	297.50	350.00	+18%
BHL	300.01	345.00	+15%
DAR	1,597.00	1,836.00	+15%

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

"ГЕРМЕС ЦЕНТР" ХК НОГДОЛ АШИГ ТАРААНА

"Гермес Центр" ХК-ийн ТУЗ-ийн тогтоолоор компанийн 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар баталгаажсан цэвэр ашгаас нэгж хувьцаанд 5.70 төгрөг, нийт 447,695,105.7 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг 2019 оны 9-р сарын 2-ны өдрөөр тогтоож, 9-р сарын 12-ны өдрөөс эхлэн "ҮЦТХТ" ТӨХК-аар дамжуулан тараахаар шийдвэрлэжээ.

"МОГОЙН ГОЛ" ХК НОГДОЛ АШГАА БАЙРШУУЛЛАА

"Могойн гол" ХК-ийн 2018 оны нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашиг болох 1,205.36 төгрөгөөс 10%-ийн албан татвар суутгасны дараах 1,084.82 төгрөгийн ногдол ашгийг 2019 оны 8-р сарын 21-ний өдөр "ҮЦТХТ" ТӨХК-аар дамжуулан, хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулжээ.

"ҮЦТХТ"-Д 8-Р САРД НЭЭГДСЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

"ҮЦТХТ"-д 8-р сард нийт 4,588 данс нээгдсэнээс 3,523 данс шинээр, 1065 данс холболтоор нээгдсэн ба шинээр нээгдсэн дансдын бүтцийг харвал 3,517 дотоодын иргэн, 4 гадаадын иргэн, 2 дотоодын аж ахуйн нэгжийн данс тус тус нээгдсэн байна.

"БАЯЛАГ СҮМБЭР" ХК-ИЙН ХУВЬЦААГ ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР САНАЛ ГАРГАЛАА

Ванвату улсын иргэн Yeh Montgomer нь "Баялаг Сүмбэр" ХК-ийн хяналтын багцыг худалдан авсан тул Компанийн тухай хуулийн 57.1 дэх заалтын дагуу бүсэд хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах тендер санал гаргажээ. Үүнд:

- Санал болгож буй үнэ: 3 /гурван/ төгрөг
- Эзэмшиж буй хувьцааны тоо: 64,661 буюу 89.6%
- Худалдан авах тоо ширхэг: 7,496 ширхэг
- Худалдан авах саналын эхлэх хугацаа: 2019-08-12
- Худалдан авах саналын дуусах хугацаа: 2019-09-16
- Худалдан авах төлбөрийн хугацаа: 2019-09-17
- Санал хүлээн авах хаяг: УБ хот, СБД, 8-р хороо, Сити центр, 1003 тоот

Дэлгэрэнгүй мэдээллийг 99087502 утсаар авна уу.

"ЛЭНДМН ББСБ" ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ СОЛИГДОВ

"ЛэндМН ББСБ" ХК-ийн ТУЗ-ийн шийдвэрээр компанийн гүйцэтгэх захирал Б.Гантулгыг өөрчилж, толгой компани Анд глобал ХХК-ийн үүсгэн байгуулагч О.Болдбаатарыг компанийн гүйцэтгэх захирлаар томилох хүсэлтийг СЗХ зөвшөөрсөн байна. Шинэ гүйцэтгэх захирал О.Болдбаатар нь санхүүч, аудитор мэргэжилтэй, дотоод гадаадын аудит компанид 15 жил ажилласан туршлагатай, ОУ-ын Мэргэшсэн нягтлан бодогч юм.

МОНГОЛ БАЗАЛТ ХК-ИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН БҮТЭЦ ӨӨРЧЛӨГДӨЖ БАЙНА

"Монгол базальт" ХК-ийн хувьцаа 2019 он гарснаас хойш 886 сая төгрөгөөр арилжигдсан. Энэ арилжааны зарсан талын дийлэнхийг дотоодын хөрөнгө оруулагчид эзлэж байгаа бол авсан талын дийлэнхийг гадны хөрөнгө оруулагчид эзлэж байна. Сүүлийн дөрвөн сарын хувьцааны арилжаанд гадны хөрөнгө оруулагчдын эзлэх хувийг дорх графикаас харах боломжтой.



Хамгийн их бууралттай

Хувьцаа	2019.06.28	2019.07.31	Өөрчлөлт, %
SON	195.00	120.00	-38%
AARD	1,911.00	1,294.00	-32%
ONH	2,660.00	1,923.00	-28%
TVT	8,925.00	7,000.00	-22%
UYN	650.00	553.00	-15%

Хамгийн их арилжигдсан


Хувьцаа	Тоо ширхэг	Үнийн дүн, сая төг	Эзлэх %
AARD	336,815	528.4	28.5%
GOV	804,172	239.7	12.9%
TTL	29,260	192.1	10.4%
APU	331,380	177.1	9.6%
INV	57,466	107.3	5.8%

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр

Компани	Нэгж үнэ, ₮	Үнэлгээ, тэрбум ₮	Эзлэх %
APU	508.50	541.1	21.7%
TTL	6,800.00	358.1	14.4%
MIK	13,700.00	283.7	11.4%
GOV	282.43	220.3	8.8%
INV	1,920.00	137.7	5.5%

Зах зээлийн үнэлгээ хамгийн бага

Компани	Нэгж үнэ, ₮	Үнэлгээ, сая ₮	Эзлэх %
HVL	55.00	2.86	-
AMT	78.00	2.82	-
SDT	57.00	2.27	-
BLG	20.00	1.13	-
BAJ	3.00	0.22	-



Мөн “Монгол базальт” ХК нь МХБ-д 2017 оноос хойш IPO гаргасан компаниудаас хамгийн олон гадаад хувьцаа эзэмшигчтэй компани болжээ.

Эх сурвалж: <https://marketinfo.mn/news/detail/39657>

ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН БҮТЦЭД ӨӨРЧЛӨЛТ ОРОВ

“Говь” ХК нь 5%-аас дээш эзэмшилтэй 3 том хувьцаа эзэмшигчтэй байсан бол “Эф Си Ай” ХХК нь өөрийн эзэмшлийн бүх хувьцааг “Таванбогд трейд” ХХК руу шилжүүлжээ. Энэ хувьцааны шилжүүлэг нь арилжааны бус хэлцлээр хийгдсэн байна.

№	Хувьцаа эзэмшигчид	Өмнөх	Дараах
1	“Эф-си-ай” ХХК	28.6%	-
2	“Hide inter” LLC	34.0%	34.0%
3	“Таванбогд трейд” ХХК	21.6%	50.2%
Нийт		84.2%	84.2%

Эх сурвалж: <https://marketinfo.mn/news/detail/39648>

САНХҮҮГИЙН ХАРЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

МХБ-д бүртгэлтэй 199 компаниас 61 компани 2019 оны хагас жилийн санхүүгийн тайлангаа илгээсэн бөгөөд үүнээс 37 компани ашигтай, 24 компани алдагдалтай ажилласан байна. Компаниудын хагас жилийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдэд ашигт ажиллагааны шинжилгээ хийлээ. Харьцааны үзүүлэлтүүдийг үнэ дансны үнийн харьцаа (P/B)-аар нь эрэмбэлэн харуулав. /Хувьцааны ханшийг 2019.09.07 өдрийн хаалтын ханшаар тооцоолов./

№	Компаниуд	Дансны үнэ	EPS, Нэгж хувьцаанд ногдох ашиг	Хаалтын ханш, 2019/09/07	P/B, Үнэ дансны үнийн харьцаа	P/E, Үнэ ашгийн харьцаа	ROA, Нийт хөрөнгийн өгөөж	ROE, Эздийн өмчийн өгөөж	Зах зээлийн үнэлгээ, сая ₮
1	БАРИЛГА КОРПОРАЦИ	310,627.2	21,603.3	405.00	0.00	0.02	0.06	0.07	16.47
2	ЗАВХАН БАЯЛАГ	5,910.1	67.5	20.00	0.00	0.30	0.00	0.01	1.13
3	ТАЛЫН ГАЛ	1,390.0	-214.6	15.87	0.01	(0.07)	(0.07)	(0.15)	11.02
4	МОНГОЛ ДИЗЕЛЬ	17,325.5	-4.0	410.63	0.02	(103.02)	(0.00)	(0.00)	56.18
5	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	1,019.1	-14.4	175.00	0.17	(12.12)	(0.01)	(0.01)	2,406.25
6	РЕМИКОН	107.2	5.9	23.01	0.21	3.92	0.02	0.05	1,810.41
7	ГАН ХЭРЛЭН	20,343.5	313.3	5,320.00	0.26	16.98	0.02	0.02	531.46
8	МОНГОЛЫН ЦА/ХОЛБОО	1,310.3	10.9	480.00	0.37	44.03	0.01	0.01	12,417.73
9	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	76,053.7	10.6	27,900.00	0.37	2,633.77	0.00	0.00	11,803.51
10	МАТЕРИАЛИМПЕКС	17,765.5	119.3	7,000.00	0.39	58.68	0.00	0.01	9,577.44
11	ХӨХ ГАН	167.4	-0.3	66.00	0.39	(225.94)	(0.00)	(0.00)	6,686.96
12	ОЛЛОО	136.6	-6.2	60.00	0.44	(9.61)	(0.04)	(0.05)	582.03
13	ХҮННУ МЕНЕЖМЕНТ	905.1	-1,929.1	427.89	0.47	(0.22)	(0.65)	(2.13)	22.17
14	АДУУН ЧУЛУУН	2,575.1	-509.2	1,500.00	0.58	(2.95)	(0.18)	(0.20)	4,726.96
15	ДОРНОД АВТО ЗАМ	4,084.8	26.8	2,580.00	0.63	96.16	0.01	0.01	193.30
16	МОНГОЛ БАЗАЛТ ХК	488.4	2.2	309.99	0.63	141.82	0.00	0.00	17,488.71
17	ТАХЬ-КО	12,882.3	356.6	10,000.00	0.78	28.04	0.03	0.03	11,899.83
18	ЖЕНКО ТУР БЮРО	89.2	0.8	70.00	0.78	83.59	0.01	0.01	7,000.00
19	ДАВААНБУЛАГ	229.5	16.7	196.65	0.86	11.76	0.07	0.07	358.52



№	Компаниуд	Дансны үнэ	EPS, Нэгж хувьцаанд ногдох ашиг	Хаалтын ханш, 2019/09/07	P/B, Үнэ дансны үнийн харьцаа	P/E, Үнэ ашгийн харьцаа	ROA, Нийт хөрөнгийн өгөөж	ROE, Эздийн өмчийн өгөөж	Зах зээлийн үнэлгээ, сая ₮
20	АЙТҮҮЛС	88.1	1.3	77.00	0.87	61.15	0.01	0.01	2,652.81
21	АТАР-ӨРГӨӨ	64,306.7	691.5	60,000.00	0.93	86.76	0.01	0.01	10,448.16
22	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	726.0	47.2	688.00	0.95	14.57	0.04	0.07	10,825.13
23	МОНИНЖБАР	121.0	-1.0	115.00	0.95	(116.15)	(0.00)	(0.01)	1,824.96
24	МОНГОЛ ШИЛТГЭЭН	272.7	0.5	311.00	1.14	672.74	0.00	0.00	3,110.00
25	ГЕРМЕС ЦЕНТР	106.2	6.1	125.00	1.18	20.40	0.06	0.06	9,817.88
26	ТЕХНИК ИМПОРТ	7,813.7	489.5	10,200.00	1.31	20.84	0.01	0.06	14,756.90
27	МИК ХОЛДИНГ	10,330.9	265.3	13,700.00	1.33	51.63	0.00	0.03	283,717.68
28	ХОРГО ХАЙРХАН	45.0	-35.2	60.00	1.33	(1.70)	(0.34)	(0.78)	8.11
29	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	105.5	-1.8	147.00	1.39	(80.00)	(0.02)	(0.02)	6,791.40
30	АПУ	360.0	8.7	509.00	1.41	58.40	0.02	0.02	541,668.41
31	ТҮМЭН ШУВУУТ	114.2	10.3	162.24	1.42	15.70	0.08	0.09	32,448.00
32	ХАСУ-МАНДАЛ	3,938.3	52.3	5,690.00	1.44	108.86	0.01	0.01	1,774.46
33	ТҮШИГ УУЛ	378.2	-0.2	550.00	1.45	(2,833.64)	(0.00)	(0.00)	2,390.17
34	АРД ДААТГАЛ ХК	457.5	53.3	704.90	1.54	13.22	0.06	0.12	17,622.50
35	МОНОС ХҮНС	42.1	0.8	65.89	1.57	79.52	0.02	0.02	26,939.15
36	УБ-БҮК	227.8	-9.8	382.00	1.68	(39.15)	(0.03)	(0.04)	50,251.15
37	МАНДАЛ ДААТГАЛ	2,931.1	545.4	5,290.00	1.80	9.70	0.08	0.19	33,025.55
38	НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ	1,211.0	17.5	2,340.00	1.93	133.80	0.00	0.01	3,015.13
39	АРД КРЕДИТ ББСБ ХК	34.2	3.8	68.35	2.00	17.88	0.06	0.11	19,138.00
40	ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ	69.4	-2.0	150.00	2.16	(76.26)	(0.02)	(0.03)	1,341.80
41	СҮҮ	88.5	12.2	195.00	2.20	16.02	0.07	0.14	67,080.00
42	МОНГОЛ ШУУДАН ХК	225.3	3.1	591.00	2.62	191.15	0.01	0.01	58,855.54
43	МОГОЙН ГОЛ	3,748.3	737.7	9,910.00	2.64	13.43	0.12	0.20	8,221.55
44	ГОВЬ	104.1	5.1	279.74	2.69	54.73	0.01	0.05	218,228.67
45	ХОРИН ХОЁРДУГААР БААЗ	141.1	-0.9	379.00	2.69	(433.53)	(0.01)	(0.01)	1,004.79
46	ЛЭНДМН ББСБ ХК	18.6	3.2	53.90	2.90	16.86	0.05	0.17	43,120.00
47	МАХИМПЕКС	778.8	114.9	2,500.00	3.21	21.76	0.04	0.15	9,501.80
48	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	30,554.7	5,209.3	110,000.00	3.60	21.12	0.11	0.17	7,189.82
49	Инвескор ББСБ	497.1	56.0	1,925.00	3.87	34.36	0.06	0.11	138,076.24
50	ТАВАН ТОЛГОЙ	1,276.3	437.0	6,700.00	5.25	15.33	0.16	0.34	352,856.84
51	СИЛК НЕТ	85.6	-2.2	708.20	8.28	(316.09)	(0.01)	(0.03)	264.88
52	ЕВРОАЗИЯ КАПИТАЛ ХОЛДИНГ	23.0	-1.4	1,150.00	49.94	(798.10)	(0.03)	(0.06)	60,111.53
53	ЭМ ЭН ДИ	14.8	-14.6	793.00	53.70	(54.34)	(0.28)	(0.99)	77.21
54	МОН НАБ	70.6	-5.7	4,500.00	63.73	(789.22)	(0.01)	(0.08)	552.45
55	МОНГОЛ СЕКЮРИТИЕС	2.3	-0.6	340.00	148.22	(605.14)	(0.10)	(0.24)	10,200.00
56	ШИНЭСТ	8,373.5	-1,368.5	100.00		(0.07)			18.47
57	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	- 29.0	4.6	715.17	(24.68)	155.59	0.02	(0.16)	26,323.87
58	ХАРХОРИН	-1,213.8	-188.4	1,750.00	(1.44)	(9.29)	(0.01)	0.16	944.15
59	ХӨНГӨН БЕТОН	- 10,045.8	-490.8	200.00	(0.02)	(0.41)	(0.02)	0.05	35.87
60	ХӨВСГӨЛ УСАН ЗАМ	-37,043.4	-637.4	430.22	(0.01)	(0.67)	(0.29)	0.02	40.62
61	ХОТ ДЕВЕЛОПМЕНТ	-19,960.0	-845.1	57.00	(0.00)	(0.07)	(2.21)	0.04	2.27



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



МӨНГӨ, ЗЭЭЛ

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2019 оны 7-р сарын эцэст 20.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 44.1 (0.2%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 3.1 (17.8%) их наяд төгрөгөөр өссөн байна. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2019 оны 7-р сарын эцэст 937.1 тэрбум болжээ.


Хүснэгт. Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018.08	2019.08*
Мөнгөний нийлүүлэлт, M2	17,211.7	20,273.5
Жилийн өөрчлөлт, %	28.6	17.8
Сарын өөрчлөлт, %	-0.8	0.2
Нийт хадгаламж	12,018.0	13,805.7
Жилийн өөрчлөлт, %	23.0	14.9
Сарын өөрчлөлт, %	2.2	-0.5
Төгрөгийн хадгаламж	9,363.2	10,898.3
Жилийн өөрчлөлт, %	29.3	16.4
Сарын өөрчлөлт, %	1.1	0.3
Валютын хадгаламж	2,654.8	2,907.4
Жилийн өөрчлөлт, %	4.8	9.5
Сарын өөрчлөлт, %	6.2	-0.9

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 7-р сарын эцэст 18.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 62.6 (0.3%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 2.8 (18.3%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 7-р сарын эцэст 877.8 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 126.7 (16.9%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 157.9 (15.2%) тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2019 оны 6-р сарын эцэст 1.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 60.5 (1.3%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 596.9 (45.3%) тэрбум төгрөгөөр өсчээ.



УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, түслэмжийн нийт хэмжээ 2019 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 6.0 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 5.5 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 535.3 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2019 оны 7-р сард 1134.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сараас 186.1 (19.6%) тэрбум төгрөгөөр өсч, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 791.5 тэрбум төгрөг болж, 110.9 (12.3%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Зураг 31. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, тэрбум төгрөг

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого	3 040.2	3 899.5	5 052.1	6 035.0
Нэгдсэн төсвийн зарлага	5 014.3	4 488.9	4 760.8	5 499.8
Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	-1 974.1	-589.4	291.3	535.3
* Урьдчилсан гүйцэтгэл	2016 I-VII	2017 I-VII	2018* I-VII	2019* I-VII

жж

Эх сурвалж: Монгол улсын үндэсний статистикийн хороо




ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Төлбөрийн тэнцлийн үрсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2019 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 639.4 сая ам. долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 138.7 сая ам. доллараар буурчээ.

Урсгал данс 683.6 сая ам. долларын алдагдалтай гарахад үйлчилгээний тэнцэл 898.3 сая ам. доллар, анхдагч орлогын данс 754.8 сая ам. долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.


Зураг 32. Бараа болон үйлчилгээний худалдааны тэнцэл, сараар, сая америк доллараар



ГАДААД ХУДАЛДАА

Монгол Улс 2019 оны эхний 7 сард дэлхийн 141 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 8.1 тэрбум ам. доллар, үүнээс экспорт 4.6 тэрбум ам. доллар, импорт 3.5 тэрбум ам. долларт хүрлээ. Харин 2019 оны 7-р сард экспорт 632.5 сая ам. доллар, импорт 613.4 сая ам. доллар болж, өмнөх сараас экспорт 43.1 сая ам. доллараар буурч, импорт 34.7 сая ам. доллараар өссөн байна.

Зураг 33. Экспорт, импорт, тэнцэл, сараар, сая америк доллар



Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 492.3 (7.8%) сая ам. доллар, үүнээс экспорт 357.6(10.0%) сая ам. доллараар, импорт 134.7 (4.9%) сая ам. доллараар тус тус өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл 2018 оны эхний хагас жилд 822.2 сая ам. долларын ашигтай гарч байсан бол 2019 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 223.0 сая ам. доллараар өсч, 1.0 тэрбум ам. долларт хүрчээ.



ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 7-р сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.1 хувиар буурч, өмнөх оны эцсээс 4.8%, өмнөх оны мөн үеэс 7.4%-р өссөн байна.

Зураг 34. Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны 12 дугаар сар =100%), хувь



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 7-р сард өмнөх оны мөн үеэс 7.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 9.5 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.0 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 9.7 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 2.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 9.1 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 8.1 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Холбоо барих хаяг

Стандарт инвестмент ҮЦК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
6-р хороо, Бага тойруу 24,
Монреимпекс ХХК-ийн байр,
2-р давхар, 201 тоот

Утас: 70114433
info@standardinvestment.mn
www.standardinvestment.mn

Шуудангийн хаяг:

Төв шуудан, Шуудангийн хайрцаг 1487
УБ - 15160

Тодруулга болон мэдэгдэл

Энэхүү тойм мэдээ нь ямар нэгэн үнэт цаасыг худалдан авах, худалдах санал биш юм. Энд дурдсан үнэ ханшийн мэдээ, бусад тоон мэдээлэл, тайлбар зэрэг нь зөвхөн тухайн мэдээллийг бэлтгэх үеийн байдлыг илтгэх бөгөөд өөрчлөгдөж, хувьсаж болно /Стандарт инвестмент ҮЦК өөрчлөлтийг мэдэгдэх албагүй/. Хөрөнгө оруулагч эрсдлийг өөрөө хариуцна.

Энэхүү тойм мэдээний бүх мэдээллийг зөвхөн мэдээлэл өгөх зорилгоор бэлдсэн бөгөөд найдвартай, сайн санааны үүднээс гаргасан гэж үзсэн эх сурвалжаас авч боловсруулсан хэдий ч мэдээлэл тус бүрийг нэг бүрчлэн хянаж шалгаагүй болно. Тиймээс Стандарт инвестмент ҮЦК нь эдгээр мэдээллийн үнэн зөв, бодит бөгөөд бүрэн бүтэн байдалд баталгаа гаргахгүй бөгөөд мэдээллийг дамжуулахаас үүссэн аливаа алдааг хариуцахгүй. Түүнчлэн, энэхүү тайланг ашигласнаас учирсан аливаа хохиролд Стандарт инвестмент ҮЦК ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

©2019 Стандарт инвестмент ҮЦК